



ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 1/53

Шивээговь сум

2021 оны A/31, A/32, A/33, A/34 дүгээр  
захирамжуудад өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг тус тус үндэслэн

**ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б/20 дугаар тушаалаар тус газрын мэргэжилтэн Н.Цэцэгжаргал нь ажлаас чөлөөлөгдсөн тул сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн A/31 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн A/32, A/33, A/34 дүгээр захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны бүрэлдэхүүний Нарийн бичгийн даргыг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Э.Халиун болгож өөрчилсүгэй.

2. Захирамжид орсон өөрчлөлтийг Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Э.Халиунд мэдэгдэж, хууль, журмын дагуу ажил үүргийг гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ



42121~92